



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/280

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 9 дүгээр
цэцэрлэгийн данснаас барилга
байгууламж, нийтийн эзэмшлийн
эд хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 96 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/708 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-093/51 дугаар актын дагуу Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах, энэ тушаалын хавсралтад заасан 33,443,583.70 /гучин гурван сая дөрвөн зуун дөчин гурван мянга таван зуун наян гурван төгрөг далан мөнгө/ төгрөгийн үнэ бүхий барилгыг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн 9 дүгээр цэцэрлэг /Д.Буянхишиг/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 9 дүгээр цэцэрлэг /Д.Буянхишиг/-т даалгасугай.

3. Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой материалыг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлсэн 4,676,620 /дөрвөн сая зургаан зуун далан зургаан мянга зургаан зуун хорин/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхийг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 31 өдрийн 0/2019 дугаар тушаалын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ,
НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ /2019.03.31/
1	Барилга /Үндсэн/	1960	м.кв	517	28,240,208.7	2,353,351.0	25,886,857.7
2	Төмөр хашаа	1960	ш	1	462,840.0	28,927.5	433,912.5
3	Зүлэгжүүлсэн талбай	1963	м.кв	400	2,386,000.0	119,300.0	2,266,700.0
4	Бетон зам	1630	м.кв	93	1,532,175.0	29,464.9	1,502,710.1
5	Шилмүүст мод	2018	ш	8	312,560.0		312,560.0
6	Улиас мод	1957	ш	24	122,400.0		122,400.0
7	Навчит мод	1957	ш	52	387,400.0		387,400.0
НИЙТ ДҮН					33,443,583.7	2,531,043.4	30,912,540.3